Судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдийн 44.1% нь худалдаа үйлчилгээ үзүүлдэг дэлгүүр болон ус суваг, 32.4% нь төрийн байгууллагууд, 13.4% нь үйлдвэрлэлийн салбар, 10.1% нь ХАА-н салбарт үйл ажиллагаа явуулж байна. Ажиллагсдын тооны хувьд судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгжүүдийн 65.1% нь 50 хүртэл ажилтантай байгууллагууд эзэлж байна (Зураг 3.1.1).



Зураг 3.1.1. Аж ахуй нэгжийн ерөнхий мэдээлэл

Төлөөллийн хувьд Сэлэнгэ аймгийн төв болон сумдуудын томоохон аж ахуйн нэгжүүдийг бүрэн хамарч чадсан.


Судалгаанд оролцсон аж ахуй нэгж, байгууллагуудын нийт ажилтнуудын 80% үндсэн ажилчид, 12.4 % нь гэрээт ажилчид, 7.6 % нь түр ажилтантай байна (Хүснэгт 3.1.1).

### Хүснэгт 3.1.1. Нийт ажиллагчид

№	Үзүүлэлт	Нийт	Хувь
1.	Нийт	7524	100
2.	Үндсэн ажилтан	5993	80
3.	Гэрээт ажилтан	934	12.4
4.	Түр ажилтан. Үүнээс	597	7.6

Сэлэнгэ аймгийн ААНБайгууллагуудын ажил эрхлэлтийг насны бүлгээр харахад 42.5 % нь 36-45 нас, 19.4 % нь 46-55 нас, 13.7 % нь 26-35 нас, 8.6 % нь 19-25 нас, 8.3% нь 56-60 нас, 4.2 % 18 нас хүртэл, 3.2 % нь 60-аас дээш насныхан байна. Үүнээс үзэхэд сум орон нутгуудад хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүсийн дунд 36-45 насныхны эзлэх хувь өндөр байна.


Ажил эрхлэлтийн байдлыг насны бүлэг болон хүйсээр авч үзвэл 18 хүртэл насны эрэгтэй 59 %, эмэгтэй 41%, 19-25 насны эрэгтэй 57 %, эмэгтэй 43 %, 26-35 насны эмэгтэй 55 % эрэгтэй 45 %, 36-45 насанд эмэгтэй 59 % эрэгтэй 41 %, 46-55 насанд эрэгтэй 58 % эмэгтэй 42 %, 56-60 насанд эрэгтэй 67%, эмэгтэй 33%, 60-аас дээш насанд эрэгтэй 68 %, эмэгтэй 32 %-ийг эзэлж байгаа нь аль насанд ямар хүмүүс илүү их хөдөлмөр эрхэлж байгааг харуулж байна (Зураг 3.1.2).



Зураг 3.1.2. Ажил эрхлэлтийн байдал насны бүлэг, хүйсээр /хувь/

ААНБайгууллагын ажиллагчдын боловсролын түвшний хувьд 45.9% нь бакалавр, 19.3% нь дипломын зэрэгтэй, 16.5% нь тусгай

мэргэжлийн дунд, 13.1% нь техникийн болон мэргэжлийн анхан шатны, бага боловсролтой, 3.7% нь магистр доктор, 1.6% нь ямар нэгэн мэргэжилгүй суурь боловсролтой байна. Иймээс эдгээр хүмүүсийг чадавхижуулах мэргэжил олгох болон богино хэмжээний сургалтанд хамруулах нь зүйтэй юм (Зураг 3.1.3).



Зураг 3.1.3. Боловсролын түвшин


Судалгаанд хамрагдагсдын 30% нь 1000.0 мянган төгрөгөөс дээш цалинтай, 27% нь 450.0-650.0 мянган төгрөг, 17% нь 850.0-1000.0 мянган төгрөг, 12% нь 350.0-450.0 мянган төгрөг, 7% нь 250.0-350.0 мянган төгрөг, 6% нь 650.0-850.0 мянган төгрөгийн цалин тус тус авч байна.

Албан хаагчид болон үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээ, үйлдвэрлэлийн мэргэжлийн ажилтнууд 450.0-650.0 мянган төгрөгийн цалин авч байгаа нь тун хангалтгүй үзүүлэлт юм. Харин инженер техникийн болон үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний мэргэжлийн ажилтны цалин 1000.0 мянган төгрөгөөс дээш байгаа нь эерэг үзүүлэлт боловч цаашид эзлэх хувийг нэмэгдүүлэх шаардлагатай байна. (Хүснэгт 3.1.2).

Хүснэгт 3.1.2. ААН Байгууллагын цалингийн шатлал /мянган.төгрөг/

д/д	Мэргэжил албан тушаал /Цалин/	Инженер техникийн ажилтан	Албан хаагч	Үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний ажилтан	Туслах үйлдвэрлэл үйлчилгээний ажилтан	Түр ба улирлын ажилтан	Мэргэжил боловсрол шаардахгүй энгийн ажилтан	Нийт	Хувь
1.	250.0-350.0	30	96	3	30	33	34	226	7
2.	350.1-450.0	5	76	67	71	32	154	405	12
3.	450.1-650.0	40	392	289	98	19	36	874	27
4.	650.1-850.0	10	67	48	31	15	30	201	6
5.	850.1-1000.0	11	15	237	287	14		564	17
6.	1000.1-с дээш	115	133	683	41			972	30
	<b>Нийт</b>	<b>211</b>	<b>779</b>	<b>1327</b>	<b>558</b>	<b>113</b>	<b>254</b>	<b>3242</b>	<b>100</b>

Ажлаас гарахад судалгаанд хамрагдагсдын 22% нь өөр ажилд шилжихээр болсон, 16% ажлын хариуцлага сахилга бат алдсан, 16% өөр газар руу шилжин суурьшсан, 13% тэтгэвэрт гарсан, 8% эрүүл мэндийн шалтгаанаар, 7% түр ажлын байранд орсон, 5% мэргэжлийн ур чадвар дутмаг, 5% цалин бага, 4% ажлын байрны орон тоо хасагдсан, 3% бусад шалтгаанууд нөлөөлдөг гэж үзсэн байна. Эдгээр шалтгаануудаас 64% нь өөрийн хүсэлтээр, үлдсэн 36% ямар нэгэн ур чадвар дутмаг хариуцлага алдсанаас болж ажил олгогч талаас санаачлан халсан байна. Иймээс ажил горилогч залуучууд өөрсдийгөө чадавхжуулах, ажлын хариуцлагатай, сахилга баттай, ачаалал даах чадвартай ажиллах, зөв хандлагатай болох тал дээр анхаарах нь зүйтэй юм (Зураг 3.1.4).



Зураг 3.1.4. Ажиллагсдын ажлаас гарсан шалтгаан


Өнөөгийн байдлаар судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдэд 21 ажлын орон тоо сул байгаа буюу техникч, тогооч, уул уурхайн инженер, цахилгааначин, сантехникч гэх мэт техник мэргэжлийн орон тоо илүү дутмаг, мөн зарим мэргэжил шаардагдах ажилд мэргэжилгүй болон өөр мэргэжлийн хүн ажиллаж байгаа нь хөдөлмөрийн эрсдэл гарах шалтгааныг нөхцөлдүүлж болзошгүй тул ажилчдыг дахин сургах, мэргэжил олгох урт болон богино хугацааны сургалтанд хамруулан мэргэжлийн хүмүүсээр хангагдах шаардлагатай байна (Хүснэгт 3.1.3).

Хүснэгт 3.1.3. Хөдөлмөрийн зах зээл дээр зохих мэргэжлийн хүн олдоогүйгээс сул байгаа болон өөр мэргэжлийн хүн ажиллаж байгаа орон тоо

№	Ажлын орон тоо	Орон тоо		Шаардлагатай мэргэжил
		Сул байгаа	Өөр мэргэжлийн хүн ажиллаж байгаа /Мэргэжлийг бичих/	
	Бүгд	63		
1	Техникч	5	Гагнуурчин	Техникч
2	Уул уурхайн инженер	5		Инженер
3	Талх нарийн боовчин	5		Тогооч

4	Троктарчин	5	Жолооч	Том тэрэгний жолооч
5	Агрономич	4		Агрономич
6	Компьютер техникч	4		Программист
7	Хөрөөчин	3	Мэргэжилгүй	Менежер
8	Ромчин, оосорлогч	3		Мэргэжилтэн
9	Суурь механист	3		Механист
10	Нярав	3		Нярав
11	Сантехникч	3	Мэргэжилгүй	Сантехникч
12	Нийгмийн ажилтан	3		Нийгмийн ажилтан
13	Малын эмч	3	Эмийн санч	Эмч
14	Цахилгаанчин	2	Мэргэжилгүй	Цахилгаанчин
15	Тэсэлгээний ажилтан	2		Тэсэлгээчин
16	Эм зүйч	2		Сувилахуйн ажилтан
17	Барилгачин	2	Мэргэжилгүй	Барилгын инженер
18	Цэцэрлэгийн багш	2	Тогооч	Цэцэрлэгийн багш
19	Оёдолчин, эсгүүрчин	2	Мэргэжилгүй	Оёдолчин
20	Мэргэжлийн эсгүүрчин	1	Мэргэжилгүй	Оёдолчин
21	Солонгос хэлний багш	1		Солонгос хэлний багш, орчуулагч

Судалгаанд 250 ААН байгууллагын 7524 хүн хамрагдсанаас 406 буюу 5.4% нь 2019-2023 онд 5 жилийн хугацаанд тэтгэвэрт гарахаар байна. Эдгээр тэтгэвэрт гарах хүмүүсийн 33.3% нь 2019 онд, 20.9% нь 2020 онд, 15.3% нь 2021 онд, 12.6% нь 2022 онд, 18% нь 2023 онд тус тус тэтгэвэрт гарахаар, салбаруудын хувьд жигд тархалттай байна. Тэтгэвэрт гарч буй хүмүүсийн хүйсийн харьцаа нь 2019 онд эмэгтэй 71.1% эрэгтэй 28.9%, 2020 онд эмэгтэй 75.3% эрэгтэй 24.7%, 2021 онд эмэгтэй 68.6% эрэгтэй 31.4%, 2022 эмэгтэй 68.6% эрэгтэй 31.4%, 2023 онд эмэгтэй 56.2% эрэгтэй 43.8% тус тус байна (Зураг 3.1.5).



Зураг 3.1.5. Өндөр настны тэтгэвэрт гарах хүний тоо

### Хүний нөөцийн бүрдүүлэлт

Шинэ ажилтан шалгаруулж авахад ямар шаардлага тавьдаг талаар судалгаа авахад ачаалал даах чадвар 15%, багаар ажиллах чадвар 15%, харилцаа хандлага 15%, мэргэжлийн ур чадвар дадал 15%, хувийн зохион байгуулалт 12%, мэргэжлийн мэдлэг 10%, мэдээллийн технологийн ур чадвар 7%, урлаг спортын ур чадвар 5%, зохих түвшний хэлний мэдлэг 4%, бусад шаардлагууд 1%-ийг эзэлж байна. Ажил олгогчдын хамгийн ихээр анхаардаг зүйл нь багаар ажиллах, ачаалал даах чадвар, хувь хүний харилцаа хандлага, мөн мэргэжлийн ур чадварууд байна (Зураг 3.1.6).



Зураг 3.1.6. Шинэ ажилтан авахад тавигдах шаардлага

ААН Байгууллагуудад бий болох орон тооны талаар судалж үзэхэд 2019 онд шинээр 159 ажлын байр, 2020 онд 51, 2021 онд 34 ажлын байр шинээр бий болохоор байна.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Орхон, Баруунхараа, Цагааннуур, Баянгол, Сант сумуудад дуу хөгжмийн багш, биеийн тамирын багш, сургууль болон цэцэрлэгийн эмч нар дутагдалтай байгаа бол Баруунхараа, Орхон, Сүхбаатар сумд газар тариалан эрхлэгчид харьцангуй олон байдаг учир трактор, комбайнчин эрэлттэй байна.

2020, 2021 онуудад техникийн мэргэжил шаардсан орон тоонууд илүү шинээр бий болох ба 2021 онд Мандал суманд хавтангийн үйлдвэр шинээр баригдах төлөвлөгөөтэй байгаа ба 15 шинэ ажлын байр шинээр бий болохоор байна. Мөн тогооч, цэцэрлэгийн туслах багш, цэцэрлэгийн багш, дуу хөгжмийн багш, сантехникч, оёдолчин засварчин зэрэг ажлын байран дээр мэргэжилгүй болон өөр мэргэжлийн хүмүүс ажиллаж байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Алтан тариа” ХХК нь нийт 220 ажилчидтай бөгөөд засварчин, малын эмч, трактор комбайнчин, саальчин, гагнуурчин, цахилгаанчин гэх мэт 16 хүнийг 2019 онд авч ажиллуулахаар байна (Хүснэгт 3.1.4).

Хүснэгт 3.1.4. Ажиллах хүчний эрэлт

№	Шинэ ажлын байрны нэр	Шинэ ажлын байранд ажиллах ажилтны орон тоо, хүн			Нийт	Орон нутаг
		2019	2020	2021		
	<b>Бүгд</b>	<b>159</b>	<b>51</b>	<b>34</b>	<b>244</b>	
1	Хавтангийн үйлдвэр			15	15	Мандал сум
2	Фермерчин	8	3	1	12	Сүхбаатар
3	Цэцэрлэгийн багш	6	3	1	10	Орхон, Сант, Баруунбүрэн, Орхонтуул
4	Туслах ажилтан	5	5		10	Сэлэнгэ, Орхонтуул, Мандал
5	Биеийн тамирын багш	5	2	2	9	Сант, Сүхбаатар, Номгон
6	Трактор комбайнчин	8			8	Ерөө, Баруунбүрэн сум



7	Эм зүйч	5	1	2	8	Түнхэл, Сүхбаатар
8	Сувилагч	5	2	1	8	Энэрэлт үйлст эмнэлэг
						Сэлэнгэ, Хүдэр
9	Эмч	7			7	Орхонтуул цэцэрлэг
						Хүдэр сургууль
						Мишээл цэцэрлэг
						Сүхбаатар 2-р цэцэрлэг
						Сүхбаатар 4-р цэцэрлэг
						Орхон сум
Сант, Цагааннуур						
10	Бүжгийн багш	4	2	1	7	Баянгол
11	Хөгжмийн багш	5	1		6	Орхонтуул ,Сант, Орхон
12	Тогооч	6	1	2	6	Сэлэнгэ, Баянгол
14	Үйлчлэгч	4	1		5	Орхонтуул сургууль
						Мандал
						Мандал
15	Агрономич	5			5	Хушаат
16	Сантехникч	3	1	1	5	Мандал, Баруунхараа, Сүхбаатар
17	Мужаан	4	1		5	Баянгол
18	Талх нарийн боовчин	3	1		4	Сүхбаатар
19	Бага ангийн багш	3	1		4	Сүхбаатар
20	Тоног төхөөрөмжийн инженер	1	1	2	4	Мандал
21	Цахилгаанчин	3	1		4	Сүхбаатар
22	Борлуулагч	2	1	1	4	Мандал
23	Нярав	1	2	1	4	Сүхбаатар , Сайхан сум
24	Галч	2	1		3	Орхонтуул
25	Инженер	2	1		3	Орхонтуул, Сайхан, Цагааннуур
26	Харуул	1	1	1	3	Сүхбаатар
27	Худалдааны төлөөлөгч	2	1		3	Сүхбаатар, Сайхан сум
29	Математикийн багш	2	1		3	Сүхбаатар 2-р сургууль
30	Оёдолчин	3			3	Баянгол, Сэлэнгэ төв
31	Ойн инженер	2	1		3	Ерөө сум
32	Гагнуурчин	3			3	Хушаат, Сүхбаатар
33	Банк санхүүгийн мэргэжилтэн	2	1		3	Цагааннуур
34	Сүүний технологич	2	1		3	Сүхбаатар
35	Жолооч	2	1		3	Зэлтэр, Ерөө
36	Зохион байгуулагч	1	1		2	Сайхан сум

37	Уулын хөрөөчин	1	1		2	Ерөө сум
38	Химийн багш	1	1		2	Орхон сум
39	Сургалтын менежер	1		1	2	Сүхбаатар 4-р сургууль
40	Зөгийчин	1		1	2	Шаамар
41	Түгээгч	1		1	2	Сүхбаатар
42	Мод бэлтгэгч	2			2	Мандал
43	Архив бичиг хэрэг	2			2	Мандал
44	Туслах багш	1	1		2	Орхон сум
46	арга зүйч	1	1		2	Сүхбаатар
47	Эрүүл ахуйч	1	1		2	Сүхбаатар
48	ХАБЭА ажилтан	1	1		2	Сүхбаатар
49	Ашиглалтын механик	1	1		2	Зэлтэр
50	Менежер	1	1		2	Сүхбаатар
51	Теллер	1	1		2	Мандал төрийн банк
52	Вип теллер	1	1		2	Мандал төрийн банк
53	Малын эмч	1	1		2	Сүхбаатар
54	Солонгос хэлний багш	1			1	Сүхбаатар
55	Нярай эмч	1			1	Сүхбаатар
56	Хүүхдийн эмч	1			1	Сүхбаатар
1.	Компьютер томографи	1			1	Мандал сум
58	Мэдээгүйжүүлэлтийн эмч	1			1	Сүхбаатар
59	Мэдрэлийн эмч	1			1	Сүхбаатар
60	Лаборонт хүнсний	1			1	Сайхан сум
61	Механик хүнсний	1			1	Сайхан сум
62	Биологийн багш	1			1	Сүхбаатар 2-р сургууль
63	Монгол хэлний багш	1			1	Сүхбаатар 2-р сургууль
64	Гадаад хэлний багш	1			1	Сүхбаатар 2-р сургууль
65	Уран зохиолын багш	1			1	Сүхбаатар 2-р сургууль
66	Харилцааны менежер	1			1	Сүхбаатар, Мандал
67	Вагон үзэгч багш	1			1	Сүхбаатар
68	Кассчин	1			1	Сүхбаатар
69	Эдийн засагч	1			1	Сүхбаатар голомт банк
70	Хүний нөөц	1			1	Сайхан сум
71	Борлуулалтын менежер	1			1	Сайхан сум
72	Эрхлэгч	1			1	Сүхбаатар Тэс петролиум
73	Мэс заслын эмч	1			1	Баянгол сум
74	Номын санч	1			1	Ерөө сум
75	Их эмч	1			1	Ерөө сум , Хүдэр, Сант

76	Эм найруулагч	1			1	Сүхбаатар
77	Дотуур байрны багш	1			1	Баруунбүрэн

### 3.1.2. Ажил эрхэлж буй залуучуудаас авсан санал асуулга

Уг судалгаанд Сэлэнгэ аймгийн 17 сумын 754 ажил, хөдөлмөр эрхлэж байгаа хүмүүс хамрагдсаны 38.2 хувийг Сүхбаатар, Мандал сумын иргэд эзэлж байна (Хүснэгт 3.1.2.1).

Хүснэгт 3.1.2.1. Судалгааны хамрагдсан сумын иргэд

		Давтамж	Хувь	Илэрхийлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь
Сум	Орхон	20	2,7	2,7	2,7
	Шаамар	30	4,0	4,0	6,6
	Хүдэр	21	2,8	2,8	9,4
	Түшиг	30	4,0	4,0	13,4
	Цагаан нуур	40	5,3	5,3	18,7
	Баруун бүрэн	20	2,7	2,7	21,4
	Зүүн бүрэн	30	4,0	4,0	25,3
	Жавхлант	20	2,7	2,7	28,0
	Сант	30	4,0	4,0	32,0
	Баянгол	50	6,6	6,6	38,6
	Хушаат	20	2,7	2,7	41,2
	Сайхан	56	7,4	7,4	48,7
	Орхон туул	20	2,7	2,7	51,3
	Сүхбаатар	145	19,2	19,2	70,6
	Алтанбулаг	31	4,1	4,1	74,7
	Ерөө	32	4,2	4,2	78,9
	Мандал	159	21,1	21,1	100,0
	<b>Нийт</b>	<b>754</b>	<b>100</b>	<b>100</b>	

Түүнчлэн судалгаанд оролцогчдын 536 нь буюу 71.1 хувийг эмэгтэйчүүд, 15-34 насны залуучууд 82.8 хувийг тус тус эзлэж байна. (Хүснэгт 3.1.2.2.)

Хүснэгт 3.1.2.2. Таны нас \* Таны хүйс

		Таны хүйс		Нийт
		эр	эм	
Таны нас	15-24	33	78	111
	24-34	156	357	513
	35-39	18	59	77
	40-45	5	24	29
	46-50	1	7	8
	51-60	5	11	16
<b>Нийт</b>		<b>218</b>	<b>536</b>	<b>754</b>

Судалгаанд оролцогчдын 67.7 хувь нь буюу 506 нь дипломын болон бакалаврын дээд боловсролтой, 11.4 хувь нь бүрэн дунд боловсролтой иргэд эзлэж байна. эмэгтэйчүүдийн 74.3 хувь, эрэгтэйчүүдийн 60.2 хувийг дипломын болон бакалаврын дээд боловсролтой иргэд эзлэж байна.

Хүснэгт 3.1.2.3. Боловсролын байдал

Таны боловсролын байдал?	Таны хүйс		Нийт	Дүнд эзлэх хувь
	эр	эм		
Дипломын болон бакалаврын дээд	130	376	506	67.7
Бүрэн дунд	31	54	85	11.4
Магистр, доктор	8	43	51	6.8
Тусгай мэргэжлийн дунд	13	32	45	6.0
Техникийн болон мэргэжлийн	20	18	38	5.1
Суурь	8	3	11	1.5
Боловсролгүй	4	4	8	1.1
Бага	2	1	3	0.4
<b>Нийт</b>	<b>216</b>	<b>531</b>	<b>747</b>	<b>100.0</b>

Бидний авсан судалгаанд төсвийн байгууллага 505 буюу 67.0 хувь, хувьцаат компани 49 буюу 6.5 хувь, хязгаарлагдмал хариуцлагатай компани 135 буюу 17.9 хувь, төрийн өмчит хувьцаат компани 20 буюу 2.7 хувьтай тус тус оролцсон байна (Хүснэгт 3.1.2.4).

Хүснэгт 3.1.2.4. Байгууллагын хариуцлагын хэлбэр

		Давтамж	Хувь	Илэрхийлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь
Хувилбар	Төсвийн байгууллага	505	67.0	68.2	68.2
	Хувьцаат компани	49	6.5	6.6	74.8
	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	135	17.9	18.2	93.0
	Төрийн өмчит хувьцаат компани	20	2.7	2.7	95.7
	Орон нутгийн өмчит компани	1	1	1	95.8
	Хоршоо	1	1	1	96.0
	Нөхөрлөл	3	4	4	96.4
	Төрийн бус байгууллага	8	1.1	1.1	97.4
	Бусад	19	2.5	2.6	100.0
	дүн	741	98.3	100.0	
Орхигдсон утга		13	1.7		
<b>Нийт</b>		<b>754</b>	<b>100.0</b>		


Сургуулиа төгсөөд аймагтаа ажиллах эсэхийг судалгаанд оролцогчдоос асууж үзэхэд 79.6 хувь нь буюу 572 иргэн тийм гэж хариулсан байгаа нь тун сайн үзүүлэлт юм. (Хүснэгт 3.1.2.5).

Хүснэгт 3.1.2.5. Аймагтаа ажиллах эсэх

д/д	Таны хувьд ажиллах ямар нөхцөл хамгийн чухал вэ?	Сургуулиа төгсөөд аймагтаа ажиллаж байгаа юу?		Нийт
		Тийм	Үгүй	
1.	Өндөр цалин хөлс	474	108	582
2.	Албаны унаа, гар утас	0	3	3
3.	Эрүүл мэндийн даатгал	30	7	37
4.	Сургалт	15	5	20
5.	Хоол, унааны зардлын хөнгөлөлт	1	0	1
6.	Хүүхдийн сургалтын төлбөрийн туслалцаа	6	2	8
7.	Өндөр насны нэмэлт тэтгэвэр олгох тогтолцоо	6	3	9
8.	Орон сууцаар хангах	24	13	37
9.	Бусад	16	6	22
	<b>Нийт</b>	<b>572</b>	<b>147</b>	<b>719</b>


Судалгаанд оролцогчдоос сүүлийн 3 жилд таны ажил өөрчлөгдөж байсан уу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 659 хүн буюу 87.4

хувь нь хариулт өгсний 168 нь буюу 25.5 хувь нь өөрчлөгдөж байсан, үлдсэн 74.5 хувь нь үгүй гэж хариулсан байна (Зураг 3.1.2.1).



Зураг 3.1.2.1. Ажил, мэргэжил өөрчлөгдөж байсан эсэх

Хэрвээ ажил өөрчлөгдсөн бол танаас ихэнхдээ хамаарч байсан уу? гэсэн асуултанд 85 хүн буюу 50,6 хувь тийм гэж хариулсан байна (Зураг 3.1.2.2).



Зураг 3.1.1.2. Ажил өөрчлөгдсөн байдал, шалтгаан

Сүүлийн 3 жилд ажиллагчдын ажил өөрчлөгдөхөд нөлөөлсөн шалтгааныг тодруулахад 48.2 хувь нь цалин хөлс бага, 27.2 хувь нь мэргэжлийн бус ажил хийж байсан, 14.9 хувь нь шууд удирдаж буй

ажилтны арга барил хэцүү байсан гэсэн хариултыг тус тус өгчээ. Эндээс ААН, байгууллагын удирдлагууд ажилтнаа тогтвор суурьшилтай ажиллуулахын тулд цалин хөлсийг оновчтой зөв тогтоох, удирдлагын арга барилыг сайжруулахад анхаарах шаардлагатай нь харагдаж байгаа юм.

Хүснэгт 3.1.2.6. Ажил өөрчлөгдөж байсан шалтгаан

		Хэрвээ "Тийм" бол ямар шалтгаантай байсан бэ?					Нийт
		Цалин хөлс бага байсан.	Ажил сонирхолгүй байсан.	Хамтран олонтойгоо баг болж ажиллаж чалахгүй байсан	Мэргэжлийн бус ажил хийж байсан.	Шууд удирдаж буй ажилтны арга барил хэцүү байсан.	
Сүүлийн 3 жилд таны ажил өөрчлөгдөж байсан уу?	Тийм	55	8	3	31	17	114
	Үгүй	17	8	4	5	1	35
<b>Нийт</b>		<b>72</b>	<b>16</b>	<b>7</b>	<b>36</b>	<b>18</b>	<b>149</b>

Судалгаанд оролцогчдын 90.1 хувь нь 250.0-850.0 мянган төгрөгийн цалин хөлс авдаг байна ( Хүснэгт 3.1.2.7).

Хүснэгт 3.1.2.7. Цалин хөлс

		Давтамж	Хувь	Дүнд эзлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь
Хувилбар	250000-400000	140	18.6	19.0	19.0
	400000-600000	385	51.1	52.3	71.3
	600000-850000	138	18.3	18.8	90.1
	850000-1000000	48	6.4	6.5	96.6
	1000000-аас дээш төгрөг	25	3.3	3.4	100.0
	Дүн	736	97.6	100.0	
Хариулаагүй		18	2.4		
<b>Нийт</b>		<b>754</b>	<b>100.0</b>		

Та сургууль төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа юу? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 63.4 хувь нь тийм гэж хариулжээ. (Хүснэгт 3.1.2.8)

Хүснэгт 3.1.2.8. Сургууль төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа байдал

		Давтамж	Хувь	Дүнд эзлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь
Хувилбар	Тийм	478	63.4	73.2	73.2
	Үгүй	175	23.2	26.8	100.0
	Дүн	653	86.6	100.0	
Хариулаагүй		101	13.4		
Нийт		754	100.0		

### 3.1.3. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдээс авсан санал асуулга

Хувиараа хөдөлмөр эрхлэлтийн судалгааны зорилго нь хувиараа хөдөлмөр эрхлэгч нэгжүүдийн өргөжих боломж, ажиллах хүчний эрэлтийн тоон ба чанарын судалгааг гаргаж, тэдгээрийн аймгийн хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурийг тодорхойлох, нягтлан зэрэгцүүлэхэд голлон чиглэгдсэн юм.

Сэлэнгэ аймгийн 19-25 насны 6, 26-35 насны 49, 36-45 насны 127, 46-55 насны 83, 55-60 насны 30, 61-ээс дээш насны 24, нийт 319 хувиараа хөдөлмөр эрхлэгчид судалгаанд хамрагдсан байна (Хүснэгт 3.1.3.1).

Хүснэгт 3.1.3.1. Судалгаанд хамрагдсан ХХЭ-ийн нас (сумдаар)

№		19-25	26-35	36-45	46-55	55-60	60-с дээш	Нийт	Хувь
1.	Алтанбулаг		6	7	3	2	1	19	6.0
2.	Баруунбүрэн		3	2	2	2		9	2.8
3.	Баянгол		4	9	5	2		20	6.3
4.	Ерөө		6	7	3	1	2	19	6.0
5.	Жавхлант		1	4	3		2	10	3.1
6.	Зүүнбүрэн		4	6	5	2		17	5.3
7.	Мандал	1	8	20	9	3	1	42	13.2
8.	Орхон сум			3	3	2	2	10	3.1
9.	Орхонтуул	2	2	3	4			11	3.4
10.	Сайхан		4	9	11	3	4	31	9.7
11.	Сант		1	2	4	2	1	10	3.1
12.	Сүхбаатар	1	4	22	6	4	7	44	13.8
13.	Түшиг			5	3	2		10	3.1



14.	Хушаат			4	3	1		8	2.5
15.	Хүдэр сум	2	2	9	3	2	2	20	6.3
16.	Цагааннуур		2	8	7	1	1	19	6.0
17.	Шаамар		2	7	9	1	1	20	6,2
	<b>Нийт</b>	<b>6</b>	<b>49</b>	<b>127</b>	<b>83</b>	<b>30</b>	<b>24</b>		
	<b>Хувиар</b>	<b>1.9</b>	<b>15.4</b>	<b>39.8</b>	<b>26.0</b>	<b>9.4</b>	<b>7.5</b>	<b>319</b>	<b>100.0</b>

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн нас хүйсний хамаарал, 71.2% нь эмэгтэй, 28.8% нь эрэгтэй, бизнес эрхлэгчдийн 39.8% нь 36-45 насны иргэд, 26% нь 45-50 насны иргэд, 15.4 % нь 26-35 насны иргэд 9.4% нь 55-60 насны иргэд байгаагаас үзэхэд хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь идэр насны хүмүүс байна (Хүснэгт 3.1.3.2).

Хүснэгт 3.1.3.2. Судалгаанд хамрагдсан ХХЭ-ийн нас, хүйс

№	Нас/хүйс	Эр	Эм	Нийт	Хувь
1.	19-25	3	3	6	1.9
2.	26-35	19	30	49	15.4
3.	36-45	40	87	127	39.8
4.	46-55	20	63	83	26.0
5.	55-60	2	28	30	9.4
6.	60-с дээш	8	16	24	7.5
7.	Нийт	92	227	319	100.0
8.	Хувь	28.8	71.2		

Эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл 146 буюу 45.8 % нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 76 буюу 23.8 % нь ХАА, 40 буюу 12.5 бөөний болон жижиглэнгийн худалдаа 1-10 буюу 0.3-3.1, нь бусад үйлчилгээг тус тус эрхэлдэг байна (Хүснэгт 3.1.3.3).

Хүснэгт 3.1.3.3. Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэл

Дд	Үйд ажиллагааны чиглэл	Тоо	Хувь
1	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	146	45.8
2	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	76	23.8
3	Бөөний болон жижиглэн худалдаа: Машин болон мотоциклын засвар үйлчилгээ	40	12.5
4	Зочид буудал, байр, нийтийн хоолны үйлчилгээ	10	3.1
5	Боловсруулах үйлдвэр	9	2.8


6	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	4	1.3
7	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	3	0.9
8	Боловсрол	3	0.9
9	Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	0.6
10	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1	0.3
11	Мэдээлэл холбоо	1	0.3
12	Хариулаагүй	24	7.5
	<b>Нийт</b>	<b>319</b>	<b>100.0</b>

Хувиараа бизнес эрхлэгчдийг насны бүлэг, ажилласан жилээр нь авч үзвэл 1 жил хүртэл ажилласан бизнес эрхлэгчдийн 12 нь 26-35 насны иргэд, 2-3 жил үйл ажиллагаагаа явуулж байгаа нь 22 иргэн, 4-5 жил үйл ажиллагаа явуулж байгаа 15 иргэн, 5-с дээш үйл ажиллагаа явуулж байгаа 85 иргэн нь 36-45 насны хүмүүс байгаа нь уг аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн зонхилох хувь нь 36-45 насны иргэд байна. Мөн бизнесийн үйл ажиллагаа эрхлээд 5-дээш жил болсон иргэд ихэнх хувийг эзэлж байна (Хүснэгт 3.1.3.4).

Хүснэгт 3.1.3.4. Бизнесийн үйл ажиллагаа эрхэлж буй жил,  
судалгаанд хамрагдагчдын нас


№	Нас /Эрхэлсэн хугацаа	1 жил хүртэл	2-3 жил	4-5 жил	5-с дээш жил	Нийт	Хувь
1	19-25	2	3		2	7	2
2	26-35	12	10	9	25	56	18
3	36-45	10	22	15	85	132	41
4	46-55	2	2	2	73	79	25
5	56-60	2	5	1	15	23	7
6	60-с дээр			3	19	22	7
	<b>Нийт</b>	<b>28</b>	<b>42</b>	<b>30</b>	<b>219</b>	<b>319</b>	<b>100</b>

Хувиараа бизнес эрхлэгчдийн санхүүжилтын эх үүсвэрээ хэрхэн шийддэг нь чухал асуудлын нэг юм. Сэлэнгэ аймгийн хэмжээгээр судалгаанд хамрагдагчдын 54% нь өөрийн хөрөнгөөр, 26% нь банкны зээлээр, 10% аль алинаар нь, 6% нь төсөлд хамрагдсан, 4% нь бусад зүйлээр санхүүждэг байна.



Зураг 3.1.3.1. Үйл ажиллагааныхаа санхүүгийн эх үүсвэрийг шийддэг байдал

Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 42 буюу 14.2% нь 1 ажилтантай, 38 буюу 12.9% нь 2-3 ажилтантай, 6 буюу 2% нь 6-10 ажилтантай, 4 буюу 1.4 10-аас дээш ажилтантай, 3 буюу 1% нь 4-5 ажилтантай байгаа нь бизнесийн цар хүрээг илэрхийлэх үзүүлэлт болж байна (Зураг 3.1.3.2).



Зураг 3.1.3.2 Танай ажиллагсдын тоо

Судалгаанд оролцсон ХХЭ-ийн ажиллагчдын 111 буюу 34.8% нь бүрэн дунд, 65 буюу 20.4% нь дипломын болон бакалавр, 56 буюу 17.6% нь, техникийн болон мэргэжлийн, 38 буюу 11.9% нь тусгай мэргэжлийн, 37 буюу 11.6% нь, бүрэн бус дунд, 6 буюу 1.9% нь огт

боловсролгүй буюу бага боловсролтой ажиллагчид байна (Хүснэгт 3.1.3.5).

Хүснэгт 3.1.3.5. Ажиллагчдын мэргэжлийн боловсролын түвшин

№	Нийт	319	100.0
1.	Бүрэн дунд	111	34.8
2.	Дипломын болон бакалаврын дээд	65	20.4
3.	Техникийн болон мэргэжлийн	56	17.6
4.	Тусгай мэргэжлийн дунд	38	11.9
5.	Суурь	37	11.6
6.	Боловсролгүй	6	1.9
7.	Бага	6	1.9
8.	Магистр, доктор	0	0.0

Сэлэнгэ аймгийн судалгаанд хамрагдсан хувиараа бизнес эрхлэгчдийн 30 орчим хувь нь ажиллах хүчний цалингийн мэдээллийг өгсөн ба тэдний ажиллагчдын 58% нь 250 000-400 000 төг, 17% хувь нь 400 000-600 000 мян.төг, 17% нь 600 000-850 000, 8% нь 850 000-1 000 000 төгрөгний цалинтай байгаа нь улсын дунджаас харьцангуй доогуур байна.

Харамсалтай нь судалгаанд хамрагсдын 217 буюу 70.2 % нь цалингийн тухай мэдээллээ бичих хүсэлгүй байна. Мөн 5-аас дээш жил үйл ажиллагаагаа явуулж буй хувиараа хөдөлмөр эрхлэгчид ажилчдыг илүү цалинжуулдаг нь хүснэгтээс харагдаж байна. (Хүснэгт 3.1.3.6).

Хүснэгт 3.1.3.6. Байгууллагын ажиллагчдын дундаж цалин

№	Дундаж цалин/Эрхэлсэн хугацаа	1 жил хүртэл	2-3 жил	4-5 жил	5-с дээш жил	Нийт	Хувь
1.	250000-400000 төг	1	2	2	2	7	58
2.	400000-600000 төг			1	1	2	17
3.	600000-850000 төг				2	2	17
4.	850000-1000000 төг				1	1	8
5.	1000000-аас төг дээш				0	0	0
	Хариулаагүй					217	70.2
	<b>Нийт</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>12</b>	<b>100</b>

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 57.7 % нь цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхолтой байхад 25.7% нь эсрэг саналтай байна. Харин 17.2% нь хариулаагүй байна. (Хүснэгт 3.1.3.7).

Хүснэгт 3.1.3.7. ААН болж өргөжих сонирхолтой эсэх

Цаашид ААН болж өргөжих сонирхолтой юу?		
Тийм	182	57.1
Үгүй	82	25.7
Хариулаагүй	55	17.2
<b>Нийт</b>	<b>319</b>	<b>100</b>

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд 2019 онд 184 ажилтан шаардлагатай байгаагаас оёдолчин, ХАА-н мэргэжилтэн, худалгач, тогооч, мал зүйч, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, зөгийчин мэргэжлийн мэргэжилтэн шаардлагатай байна. Харин 2020 онд 72, 2021 онд 50 ажилтан нийт 306 ажилтан шаардлагатай байна. (Хүснэгт 3.1.3.8)

Хүснэгт 3.1.3.8. Ажиллах хүчний эрэлт

дд	Ажлын байр	2019	2020	2021	Нийт
<b>Үйлдвэрлэл үйлчилгээний үндсэн мэргэжлийн ажилчин</b>					
1	Оёдолчин	11	5	7	23
2	ХАА-н мэргэжилтэн	17			17
3	Худалдагч	7	5	1	13
4	Тогооч	10	3		13
5	Мал зүйч	2	2	4	8
6	Сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэгч	1	2	5	8
7	Зөгийчин	3	2	2	7
8	Нарийн боовчин	7			7
9	Үсчин	4	1	1	6
10	Автын засварчин	2	4		6
11	Ногоочин	2	2	1	5
12	Мужаан	1	2		3
13	Туслах оёдолчин	1	1	1	3
14	Маникьюр	2	1		3
15	Гоо сайханч	2	1		3
16	Гуталчин	1	1		2
17	Хүнсний технологич	2			2
18	Гагнуурчин	2			2

19	Эсгүүрчин	1			1
20	Авто засварчин		1		1
21	Нярав	1			1
22	Агро техник	1			1
23	Зөөгч	1			1
24	Цахилгаанчин	1			1
25	Автоын цахилгаанчин	1			1
26	Борлуулагч	1			1
27	Трактор комбайнчин	1			1
28	МАА-н ажилтан			1	1
29	Зоотехникч	1			1
30	Программист	1			1
31	Малын эмч	1			1
32	Педикьер		1		1
	Дүн	88	34	23	145
<b>Мэргэжлийн туслах ажилчин</b>					
1	Мэргэжлийн туслах ажилтан	15	10	9	34
2	туслах ногоочин	15			15
3	Мэргэжлийн туслах ажилтан мужаан	5	5	2	12
4	Туслах тогооч	5			5
5	Туслах оёдолчин	1	1	1	3
6	Авто засварчины туслах	1			1
	Дүн	42	16	12	70
<b>Түр ба улирлын ажилчин /Боловсрол шаардахгүй/</b>					
1	Туслах малчин	28	6	3	37
2	Түр ажилчин	19	9	5	33
3	Энгийн ажилтан	2	3	5	10
4	Саальчин	1	2	1	4
5	Малчин	1	2	1	4
	Дүн	51	22	15	88
<b>Мэргэжил боловсрол шаардахгүй энгийн ажилчин</b>					
1	Үйлчлэгч	2			2
2	Оёдолчин	1			1
	Дүн	3	0	0	3
	<b>Нийт</b>	<b>184</b>	<b>72</b>	<b>50</b>	<b>306</b>

### 3.1.4. Малчин өрхөөс авсан санал асуулга

Сэлэнгэ аймаг нь 2017 оны малын тоо 1509925 толгой болж урьд оноос 89.8 мянган толгой буюу 5.6 хувиар буурсан. Нийт малтай өрхийн тоо 9541 болсон нь 2016 онтой харьцуулахад 24 өрхөөр

хасагдсан байна. 200 хүртэлх малтай 7171 өрх, 201-999 хүртэлх малтай 2220 өрх, 1000 болон түүнээс дээш малтай 150 өрх 2017 онд тоологдсон байна.<sup>1</sup>

Хүснэгт 3.1.4.1. 2017 оны мал тооллогын дүнгээр малын тоо<sup>2</sup>

дд	Сумын нэр	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
<b>Бүгд</b>		<b>1,509,925</b>	<b>95,447</b>	<b>218,403</b>	<b>507</b>	<b>699,295</b>	<b>496,273</b>
1	Сүхбаатар	21,116	1,902	5,758		6,216	7,240
2	Алтанбулаг	52,148	2,987	10,046	2	24,425	14,688
3	Баруунбүрэн	170,822	9,540	16,874	49	87,021	57,338
4	Баянгол	138,559	9,059	16,635		71,845	41,020
5	Ерөө	63,642	4,958	11,991		25,351	21,342
6	Жавхлант	82,135	4,675	10,054		38,929	28,477
7	Зүүнбүрэн	69,775	3,868	11,390		31,274	23,243
8	Мандал	101,674	11,818	27,224	50	32,376	30,206
9	Орхон	104,946	6,374	13,131		45,865	39,576
10	Орхонтуул	184,757	13,068	16,977	403	88,264	66,045
11	Сайхан	93,147	5,870	13,144		43,972	30,161
12	Сант	83,054	4,556	11,347	3	40,694	26,454
13	Түшиг	58,832	3,383	9,257		28,099	18,093
14	Хүдэр	28,432	2,700	7,875		10,374	7,483
15	Хушаат	72,988	2,977	9,899		35,755	24,357
16	Цагааннуур	162,235	6,056	20,161		81,572	54,446
17	Шаамар	21,663	1,656	6,640		7,263	6,104

Сэлэнгэ аймгийн хэмжээгээр 8278 малчид байгаагийн 2463 нь буюу 29.8 хувь нь 16-34 насных, 4704 нь буюу 56.8 хувь нь 35-54 насны эм, 35-59 насны эрэгтэйчүүд, үлдсэн 13.4 хувийг 55 ба түүнээс дээш насны эм, 60 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд эзлэж байна (Хүснэгт 3.1.4.2).

<sup>1</sup> [http://www.selenge.nso.mn/uploads/users/75/files/2017\\_12-%D1%81%D0%B0%D1%80-emhetgel%20negtgel\\_1.pdf](http://www.selenge.nso.mn/uploads/users/75/files/2017_12-%D1%81%D0%B0%D1%80-emhetgel%20negtgel_1.pdf)

<sup>2</sup> [http://www.selenge.nso.mn/uploads/users/75/files/2017\\_12-%D1%81%D0%B0%D1%80-emhetgel%20negtgel\\_1.pdf](http://www.selenge.nso.mn/uploads/users/75/files/2017_12-%D1%81%D0%B0%D1%80-emhetgel%20negtgel_1.pdf)

### Хүснэгт 3.1.4.2. Малчдын тоо

дд	Сумын нэр	Нийт малчдын тоо	Бусад	16-34 насны	35-54 насны эм, 35-59 насны эр	55 ба түүнээс дээш насны эм, 60ба түүнээс дээш насны эр	нийт малчдаас эрэгтэй	Нийт малчдаас эмэгтэй
	<b>Бүгд</b>	<b>8,278</b>	<b>14</b>	<b>2,463</b>	<b>4,704</b>	<b>1,097</b>	<b>4,808</b>	<b>3,470</b>
1	Сүхбаатар	199		38	149	12	128	71
2	Алтанбулаг	399	1	96	231	71	225	174
3	Баруунбүрэн	894		313	448	133	495	399
4	Баянгол	719		156	434	129	409	310
5	Ерөө	498		143	302	53	269	229
6	Жавхлант	485		149	261	75	305	180
7	Зүүнбүрэн	498	1	171	276	50	286	212
8	Мандал	916	5	213	533	165	510	406
9	Орхон	389	1	108	233	47	226	163
10	Орхонтуул	696		214	407	75	438	258
11	Сайхан	411		122	252	37	244	167
12	Сант	426	1	140	242	43	259	167
13	Түшиг	148		45	85	18	106	42
14	Хүдэр	165		57	82	26	109	56
15	Хушаат	437	4	140	237	56	243	194
16	Цагааннуур	830	1	326	418	85	455	375
17	Шаамар	168		32	114	22	101	67

Малчин өрхөөс авсан судалгаанд нийт 158 өрх хамрагдсаны 5-6 гишүүнтэй өрх гэр 45.6 хувийг, 3-4 гишүүнтэй өрх 32.3 хувийг эзлэж байгаа байна (Хүснэгт 3.1.4.3).

### Хүснэгт 3.1.4.3. Ам бүлийн тоо

Ам бүлийн тоо	Өрх	Дүнд эзлэх хувь	Өсөн нэмэгдэх хувь
1 - 2	17	10.8	10.8
3 - 4	51	32.3	43.0
5 - 6	72	45.6	88.6
7-дээш	16	10.1	98.7
бөглөөгүй	2	1.3	100.0
Нийт дүн	158	100	

Судалгаанд оролцсон малчин өрхийн 82.9 хувь нь буюу 130 өрх 501-ээс толгой малтай, 11 өрх буюу 7.0 хувь нь 101-300 толгой малтай, 9



өрх буюу 5.7 хувь нь 301-500 толгой малтай, 5 өрх буюу 3.2 хувь нь 100 хүртэл толгой малтай өрх байна (Хүснэгт 3.1.4.4).

Хүснэгт 3.1.4.4. Малын тоо

Малын тоо	Ам бүлийн тоо					Нийт тоо	Хувиар
	1-2	3-4	5-6	7-оос дээш	Хариулаагүй		
100 хүртэл	1	2	2			5	3.2
101-300	1	9	1			11	7.0
301-500		2	6	1		9	5.7
501-1000	10	24	49	12		95	60.1
1000-аас дээш	5	13	13	5		36	22.8
Хариулаагүй			1		1	2	1.3
<b>Нийт</b>	<b>17</b>	<b>50</b>	<b>72</b>	<b>18</b>	<b>1</b>	<b>158</b>	<b>100.0</b>

Судалгаанд оролцогч малчин өрхийн 50.6 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан, үлдсэн 39.9 хувь нь хамрагдаагүй байна. Иймд малчидад нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар сургалт явуулах, мэдээллээр хангах хэрэгтэй байна (Хүснэгт 3.1.4.5).

Хүснэгт 3.1.4.5. Нийгмийн даатгалд хамрагдсан байдал

Ам бүлийн тоо	тийм	үгүй	Тэтгэвэрт	Хариулаагүй	Нийт тоо	Хувиар
1-2	9	4	1	3	17	10.8
3-4	27	21		2	50	31.6
5-6	32	33		7	72	45.6
7-оос дээш	12	5		1	18	11.4
Хариулаагүй				1	1	0.6
<b>Нийт тоо</b>	<b>80</b>	<b>63</b>	<b>1</b>	<b>14</b>	<b>158</b>	<b>100.0</b>
<b>хувиар</b>	<b>50.6</b>	<b>39.9</b>	<b>0.6</b>	<b>8.9</b>	<b>100.0</b>	

Судалгаанд оролцсон малчин өрхүүдээс 62.6 хувь нь туслах малчингүй, 58 өрх буюу 37.4 хувь нь туслах малчин авч ажиллуулдаг байна. Малын тоогоор нь авч үзвэл 501-дээш толгой малтай өрх туслах малчинг авч ажиллуулж байна (Хүснэгт 3.1.4.6).

Хүснэгт 3.1.4.6. Туслах малчин

Малын тоо	Туслах малчин		Нийт
	тийм	үгүй	
100 хүртэл	2	3	5
101-300	3	8	11
301-500	1	8	9
501-1000	35	59	94
1000-аас дээш	17	19	36
<b>Нийт</b>	<b>58</b>	<b>97</b>	<b>155</b>
<b>Хувь</b>	<b>37.4</b>	<b>62.6</b>	<b>100.0</b>

Туслах малчинтайгаа хөдөлмөрийн гэрээ байгуулдаг эсэхийг судалгаанд оролцогчдоос асуухад туслах малчинтай өрхийн 54 нь буюу 93.1 хувь нь хөдөлмөрийн гэрээтэй байгуулдаг байна. Хөдөлмөрийн гэрээг бичгээр байгуулсан малчин өрх 5 буюу 8.6 хувийг эзлэж байгаа нь хөдөлмөрийн тухай хуулийг зөрчиж байгаа явдал юм. Амаар байгуулсан гэрээг хөдөлмөрийн гэрээ байгуулсан гэж үзэх үү? гэдэг асуудал гарч байна (Хүснэгт 3.1.4.7).

Хүснэгт 3.1.4.7. Хөдөлмөрийн гэрээ

Малын тоо	Хөдөлмөрийн гэрээтэй эсэх			Нийт
	Амаар байгуулсан	Бичгээр байгуулсан	үгүй	
100 хүртэл	2			2
101-300	3			3
301-500	1			1
501-1000	30	4	1	35
1000-аас дээш	13	1	3	17
<b>Нийт</b>	<b>49</b>	<b>5</b>	<b>4</b>	<b>58</b>
<b>Хувь</b>	<b>84.5</b>	<b>8.6</b>	<b>6.9</b>	<b>100.0</b>

Туслах малчин авч ажиллуулж байгаа малчин өрхийн 50.0 хувь нь бэлэн мөнгөөр цалинжуулж, үлдсэн 22.4 хувь нь малжуулдаг, үлдсэн 27.6 хувь нь мөнгөн бус хэлбэрээр болон цалинг хослуулан олгодог байна (Хүснэгт 3.1.4.8).

Хүснэгт 3.1.4.8. Туслах малчинд олгож буй цалин

Малын тоо	Бэлэн мөнгө	Мөнгөн бус хэлбэрээр	Малжуулах	Холимог	нийт
100 хүртэл	1	1		1	3
101-300		1		2	3
301-500				1	1
501-1000	17	4	13		34
1000-аас дээш	11	2		4	17
<b>Нийт</b>	<b>29</b>	<b>8</b>	<b>13</b>	<b>8</b>	<b>58</b>
<b>Хувь</b>	<b>50.0</b>	<b>13.8</b>	<b>22.4</b>	<b>13.8</b>	<b>100.0</b>

Туслах малчин жилийн аль улиралд авч ажиллуулдаг талаар судлахад 38 малчин өрх буюу 65.5 хувь жилийн турш ажиллуулдаг, 13 буюу 22.4 хувь нь хаврын улиралд үлдсэн 12.1 хувь нь өвөл, хаврын улиралд туслах малчин ажиллуулдаг байна (Хүснэгт 3.1.4.9).

Хүснэгт 3.1.4.9. Жилийн аль улиралд туслах малчин ажиллуулдаг байдал

Малын тоо	Жилийн турш	Хаврын улиралд	Өвөл, хавар	нийт
100 хүртэл	3			3
101-300	2		1	3
301-500			1	1
501-1000	23	8	3	35
1000-аас дээш	10	5	2	17
<b>Нийт</b>	<b>38</b>	<b>13</b>	<b>7</b>	<b>58</b>
<b>Хувь</b>	<b>65.5</b>	<b>22.4</b>	<b>12.1</b>	<b>100</b>

Та цаашид туслах малчин авч ажиллуулах уу? гэсэн асуултанд судалгаанд ороцлогчдын 83 малчин өрх буюу 52.9 хувь нь 2019-2021 онд туслах малчин авна гэж хариулсан байна (Хүснэгт 3.1.4.10).

Хүснэгт 3.1.4.10. Туслах малчны хэрэгцээ

Малын тоо	тийм	үгүй	нийт
100 хүртэл	3	2	5
101-300	8	4	12
301-500	3	6	9
501-1000	44	51	95
1000-аас дээш	25	11	36
<b>Нийт</b>	<b>83</b>	<b>74</b>	<b>157</b>
<b>Хувь</b>	<b>52.9</b>	<b>47.1</b>	<b>100.0</b>

Туслах малчны хэрэгцээний таамаглалаас үзэхэд 2019 онд 54, 2020 онд 37, 2021 онд 20 туслах малчин шаардлагатай байна. Энэ асуултанд 1000-аас дээш толгой малтай өрхийн ихээхэн нь туслах малчин авахаар байна. Бас 1 анхаарал татсан асуулт бол 100 хүртэл толгой малтай 1 ам бүлтэй, 3-4 ам бүлтэй өрх туслах малчин авахаар санал өгсөн бөгөөд тэд үйл ажиллагаагаа өргөжүүлж ХХК болох хүсэлтэй байна (Хүснэгт 3.1.4.11).

Хүснэгт 3.1.4.11. Хэрэгцээт малчны тоо

Хүний тоо	2019	2020	2021	Нийт
1	38	25	13	76
2	14	10	7	31
Гэр бүлээр нь	2	2		4
<b>Нийт</b>	<b>54</b>	<b>37</b>	<b>20</b>	<b>111</b>

### Хэсгийн дүгнэлт

1. Ажил олгогч ААНБайгууллагын судалгаанд 250 байгууллага оролцсоноос 44.1% нь худалдаа үйлчилгээ үзүүлдэг дэлгүүр, ус суваг, 32.4% нь төрийн байгууллагууд, 13.4% нь үйлдвэрлэлийн салбар, 10.1% нь ХАА-н салбарын аж ахуй нэгжүүд байна.

Судалгаанд оролцсон аж ахуй нэгж, байгууллагуудын нийт ажилчдын 80% нь үндсэн, 12.4 % нь гэрээт, 7.6 % нь түр ажилчид байна.

Судалгаанд хамрагдагсдын 30% нь 1сая төгрөгөөс дээш, 27% нь 450.0-650.0 мянган төгрөг, 17% нь 850.0-1 сая төгрөг, 12% нь 350.0-450.0 мянган төгрөг, 7% нь 250.0-350.0 мянган төгрөг, 6% нь 650.0-850.0 мянган төгрөгийн цалинтай байна. Хамгийн өндөр цалинтай хэсэг (30%)-ийн 68.2%-ийг үндсэн үйлдвэрлэл үйлчилгээний ажилтнууд эзэлж байгаа нь нарийн мэргэжлийн ажиллагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг харуулж байна.

Судалгаанд хамрагдагсдын 64% нь өөрийн хүсэлтээр, үлдсэн 36% ямар нэгэн ур чадвар дутмаг, хариуцлага алдсанаас болж ажлаас чөлөөлөгдсөн байна.

Өнөөгийн байдлаар судалгаанд хамрагдсан аж ахуй нэгжүүдэд сул орон тоо 63 байгаагаас техникч, тогооч, уул уурхайн инженер, цахилгаанчин, сантехникч гэх мэт мэргэжлийн орон тоо дутмаг байна. Харин техникч, тракторчин, сантехникч, цахилгаанчин, барилгачин, цэцэрлэгийн багш, цэцэрлэгийн туслах багш, дуу хөгжмийн багш, малын эмч, оёдолчин, засварчин зэрэг орон тоон дээр мэргэжлийн бус болон мэргэжилгүй хүмүүс ажиллаж байгаа нь дээрх мэргэжлүүдийн эрэлт их, шаардлагатай урт болон богино хугацааны сургалтанд хамруулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Судалгаанд 250 ААНБайгууллагаас 2019 онд 135 хүн, эмэгтэй 71.1% эрэгтэй 28.9%, 2020 онд 85 хүн, эмэгтэй 75.3% эрэгтэй 24.7%, 2021 онд 62 хүн, эмэгтэй 68.6% эрэгтэй 34.4%, 2022 онд 51 хүн, эмэгтэй 68.6% эрэгтэй 31.4%, 2023 онд 73 хүн, эмэгтэй 56.2% эрэгтэй 43.8% тус тус тэтгэвэрт гарахаар байна.

ААНБайгууллагуудад 2019 онд шинээр 159 ажлын байр, 2020 онд 51, 2021 онд 34 ажлын байр шинээр бий болохоор байна.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул, Орхон, Баянгол, Цагааннуур, Баянгол, Сант сумуудад дуу хөгжмийн багш, биеийн тамирын багш, сургууль болон цэцэрлэгийн эмч нар дутагдалтай байгаа бол тариалангийн бүсийн Баянгол, Орхон, Сүхбаатар сумдад трактор, комбайнчны мэргэжил эрэлттэй байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын “Алтан тариа” ХХК нь нийт 220 ажилчидтай бөгөөд засварчин, малын эмч, троктар комбайнчин, саальчин, гагнуурчин, цахилгаанчин, гэх мэт 16 хүн 2019 онд авч ажиллуулахаар байна.

2021 онд Мандал суманд хавтангийн үйлдвэр шинээр баригдах төлөвлөгөөтэй байгаа ба 15 шинэ ажлын байр шинээр бий болохоор байна.

2. Судалгаанд 19 сумын 754 ажиллаж буй залуучууд хамрагдсанаас 38.2%-ийг Сүхбаатар, Мандал сумын иргэд эзэлж байна. Судалгаанд хамрагдсан ажиллаж буй иргэдийн 536 буюу 71.1% нь эмэгтэй байсан бол 5-34 насны залуучууд 82,8%-ийг эзэлж байлаа.

Судалгаанд оролцогчдоос төсвийн байгууллагад 505 буюу 67.0%, хувьцаат компанид 49 буюу 6.5%, хязгаарлагдмал хариуцлагатай компанид 135 буюу 17.9%, төрийн өмчит хувьцаат компанид 20 буюу 2.7% нь ажиллаж байгаа.

Тэдгээрийн 168 нь буюу 25,5% нь сүүлийн 3 жил ажлаа өөрчилсний 48.2% нь цалин хөлс бага, 27.2% нь мэргэжлийн бус ажил хийж байсан, 14,9% нь шууд удирдаж буй ажилтны арга барилтай нийцгүй гэсэн шалтгаанаар гарсан. Эндээс цалин хөлс чухал хүчин зүйл болохын зэрэгцээ байгууллагын удирдлагын арга барилыг ч анхааралгүй орхиж болохгүй нь харагдаж байна.

3. Судалгаанд 19 сумын 319 хувиараа хөдөлмөр эрхлэгчдид хамрагдсанаас 71.2% нь эмэгтэй, 28.8% нь эрэгтэй, бизнес эрхлэгчдийн 39.8% нь 36-45 насны иргэд, 26% нь 45-50 насны иргэд, 15.4 % нь 26-35 насны иргэд 9.4% нь 55-60 насны иргэд байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн дийлэнх нь идэр насны хүмүүс байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээгээр судалгаанд хамрагдсан ХХЭ-ийн 54% нь өөрийн хөрөнгө, 26% нь банкны зээл, 10% аль алианаар нь, 6% нь төсөл, 4% нь бусад эх үүсвэрээс санхүүждэг байна.

Судалгаанд хамрагдсан хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 42 буюу 14,2% нь 1 ажилтантай, 38 буюу 12,9% нь 2-3 ажилтантай, 6 буюу 2% нь 6-10 ажилтантай, 4 буюу 1,4 10-аас дээш ажилтантай, 3 буюу 1% нь 4-5 ажилтантай байгаа нь тэдгээрийн бизнесийн цар хүрээг илэрхийлэх үзүүлэлт болж байна.

Сэлэнгэ аймгийн хувиараа бизнес эрхлэгчдийн ажиллах хүчний 58% нь 250.0-400.0 мян.төг, 17% хувь нь 400.0-600.0 мян.төг, 17% нь 600.0-850.0 мян.төг, 8% нь 850.0-1 сая төгрөгний цалинтай байгаа нь улсын дунджаас харьцангуй доогуур байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 57,7% нь цаашид үйл ажиллагаагаа өргөжүүлэх сонирхолтой байна.

4. Сэлэнгэ аймгийн хэмжээгээр 8278 малчид байгаагийн 2463 нь буюу 29,8% нь 16-34 насных, 4704 нь буюу 56.8% нь 35-54 насны эмэгтэй, 35-59 насны эрэгтэйчүүд, үлдсэн 13.4 хувийг 55 ба түүнээс дээш насны эмэгтэй, 60 ба түүнээс дээш насны эрэгтэйчүүд эзэлж байна.

Судалгаанд оролцогч малчин өрхийн 50.6 хувь нь нийгмийн даатгалд хамрагдсан, үлдсэн 39.9 хувь нь хамрагдаагүй байна. Иймд малчидад нийгмийн даатгалд хамрагдахын ач холбогдлын талаар сургалт явуулах, мэдээллээр хангах хэрэгтэй байна.

Судалгаанд оролцсон малчин өрхүүдээс 62.6% нь туслах малчингүй, 58 өрх буюу 37.4% нь туслах малчин авч ажиллуулдаг байна. Малын тоогоор нь авч үзвэл 501-дээш толгой малтай өрх туслах малчинг авч ажиллуулж байна.


Судалгаанд ороцлогчдоос 83 малчин өрх буюу 52.9% нь 2019-2021 онд туслах малчин авах саналтай байгаагаас 2019 онд 54, 2020 онд 37, 2021 онд 20 туслах малчин шаардлагатай байна. 1000-аас дээш толгой малтай өрхийн ихээхэн нь туслах малчин авахаар байна. Бас 1 анхаарал татсан асуулт бол 100 хүртэл толгой малтай 1 ам бүлтэй, 3-4 ам бүлтэй өрх туслах малчин авахаар санал өгсөн бөгөөд тэд үйл ажиллагаагаа өргөжүүлж ХХК болох хүсэлтэй байна.

### **3.2 Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн чанарын судалгааны дүн**

Сэлэнгэ аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн чанарын судалгааны дүнг судалгааны объект тус бүрээр харуулав.

### 3.2.1. Ажил олгогчдоос авсан санал асуулга

Шинэ ажилтан авахад ямар бэрхшээл тулгардаг вэ? гэсэн асуултанд хариулсан байдлыг авч үзвэл: Судалгаанд хамрагдагсдын 22.7% нь мэргэжлийн хүн олдохгүй, 20.8% нь цалин голдог, цаг баримталдаггүй, 15.9% нь мэргэжлийн ур чадвар дадал дутагдалтай, 15.6% нь санаачлагагүй, 13.9% харилцаа хандлага төлөвшил муу, 11% нь мэргэжлийн мэдлэг хангалтгүй гэсэн бэрхшээлүүд тулгардаг байна (Зураг 3.2.1.1).



Зураг 3.2.1.1. Ажил олгогчид ажилтан авахад тулгардаг бэрхшээл

Мэргэжлийн чиглэлээр ажилладаг МСҮТ, коллеж, сургалтын байгууллагатай хамтран ажилладаг уу? гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 33.3% хувь нь тийм, 66.7% нь үгүй гэж хариулсан, тийм гэж хариулсан байгууллагуудаас хамтын ажиллагааны гэрээтэй юу? гэсэн асуулт асуухад 20.4% нь тийм буюу гэрээтэй, 79.6% нь үгүй гэж хариулжээ.

Хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагуудаас оюутан авч ажлын байранд дадлагажуулдаг уу? гэсэн асуултанд 23.2% нь тийм,



76.8% нь үгүй гэж тус тус асуултгын хуудсыг бөглөсөн байна (Хүснэгт 3.2.1.1).

Хүснэгт 3.2.1.1. Оюутнуудыг дадлага хийлгэдэг эсэх

МСҮТ, коллеж, сургалтын байгууллага гатай хамтран ажилладаг уу?	Тийм	33.3	Хамтын ажиллагааны гэрээтэй юу?	Тийм	22.4	Оюутан авч ажлын байранд дадлагажуулдаг уу?	Тийм	23.2
				Үгүй	79.6		Үгүй	76.8
	Үгүй				66.7			


Мэргэжлийн сургуульд та ямар хүсэлт тавимаар байна вэ? гэсэн асуултанд 13.5% нь мэргэжлийн ур чадвар дутмаг, 12.2% нь ажлын байранд дадлагажуулах, 11.5% нь практик ур чадвар дутмаг, 10.1% нь хувийн зохион байгуулалт сайтай хүн, 9.5% нь ажилчдыг мэргэшүүлэх, 9.5% нь МСҮТ-д зарим нэг ангиудыг нэмэх, 9.5% нь хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар сургах, 7.4% хувь хүний харилцаа, 6.8% нь сургалтын чанарыг сайжруулах, 5.4 % нь эрүүл ахуйн боловсрол, 4.7% нь нарийн мэргэжлээр суралцагчдын суралцах хугацааг уртасгах гэсэн хүсэлтийг тус тус тавьсан байна. (Хүснэгт 3.2.1.2).

Хүснэгт 3.2.1.2. Мэргэжлийн сургуульд тавих хүсэлт салбарын ангиллаар(тоогоор болон хувиар илэрхийлсэн)

Үзүүлэлтүүд		Салбарууд						Нийт	Хувь	
		ХАА	Боловсрол	Худалдаа Үйлчилгээ	Төрийн алба	Аж үйлдвэр	Банк			
Мэргэжлийн сургуульд тавих хүсэлт	Мэргэжлийн ур чадвар	Хувь	25	20	0	5	20	30	<b>100</b>	13.5
		Тоо	5	4		1	4	6	<b>20</b>	
	Ажлын байранд дадлагажуулах	Хувь	0	16.7	5.6	0	33.3	44.4	<b>100</b>	12.2
		Тоо	0	3	1	0	6	8	<b>18</b>	
	Практик ур чадвар	Хувь	29	12	12	12	35	0	<b>100</b>	11.5
		Тоо	5	2	2	2	6		<b>17</b>	
	Хувийн зохион байгуулалт сайтай	Хувь	0	20	20	0	26.7	33.3	<b>100</b>	10.1
		Тоо	0	3	3	0	4	5	<b>15</b>	
	Ажилчдыг мэргэшүүлэх	Хувь	21	0	0	21	57		<b>100</b>	9.5
		Тоо	3	0	0	3	8	0	<b>14</b>	
	МСҮТ-д зарим анги орон тоог нэмэх	Хувь	21	0	0	0	79	0	<b>100</b>	9.5
		Тоо	3	0	0	0	11	0	<b>14</b>	
	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Хувь	25	0	0	0	0	75	<b>100</b>	9.5
		Тоо	2	4			2	6	<b>14</b>	
	Хувь хүний харилцаа хандлага	Хувь	0	0	0	18	9	73	<b>100</b>	7.4
		Тоо	0	0	0	2	1	8	<b>11</b>	
	Сургалтын чанарыг сайжруулах	Хувь	0	50	0	0	50	0	<b>100</b>	6.8
		Тоо	0	5	0	0	5	0	<b>10</b>	
Эрүүл ахуйн боловсрол	Хувь	0	75	0	0	25	0	<b>100</b>	5.4	
	Тоо	0	6	0	0	2	0	<b>8</b>		
Нарийн мэргэжлээр суралцагчдын суралцах хугацааг уртасгах	Хувь	0	28.6	42.9	0	28.6	0	<b>100</b>	4.7	
	Тоо	0	2	3	0	2	0	<b>7</b>		
<b>Нийт</b>	<b>Хувь</b>	<b>13</b>	<b>17</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>34</b>	<b>24</b>	<b>100</b>	<b>100</b>	
	<b>Тоо</b>	<b>18</b>	<b>29</b>	<b>9</b>	<b>8</b>	<b>51</b>	<b>33</b>	<b>148</b>		

Хүний нөөцийн сургалт

Сүүлийн 3 жилийн байдлаар судалгаанд хамрагдсан ААНБайгууллагын 25% нь ажилчдаа сургалтанд хамруулдаг байна. Сургалтын төрлүүдийг харвал мэргэжлийн сургалтанд 34.4%, хувь хүний хөгжлийн сургалт 28.8%, мэргэжил олгох сургалт 16.7%, дагалдан сургалт 7.9%, үйлдвэрлэл дээр 7.1% үйлдвэрлэл дээр мэргэжил дээшлүүлэх 5% байна. Энэ нь ажил олгогч нар ажилчдаа чадавхжуулах сургалтанд хамруулах хэрэгцээтэй байгаа боловч ААНБайгууллагууд ажилтнаа сургалтанд хамруулах сонирхолгүй байгаа нь харагдаж байна. Иймд ААНБайгууллагын удирдлагуудыг чадавхжуулах, мэдээллээр ханган, хамтран ажиллах шаардлагатай байна ( Зураг 3.2.1.2).



Зураг 3.2.1.2. Хүний нөөцийн сургалт

Танай ААНБайгууллага сүүлийн 1 жилд их дээд сургууль, МСҮТ коллеж төгсөгчдөөс ажилд авсан уу? гэсэн асуултанд судалгаанд хамрагдагсдын 33% нь тийм, 67% нь үгүй гэж хариулсан байна. Тийм бол ямар мэргэжлээр аль сургуулиас хэдэн төгсөгч авсан талаарх нээлттэй асуултанд дараах байдлаар хариулсан байна.


Сэлэнгэ аймгийн хөдөлмөр эрхлэгчид ихэвчлэн Дархан-Уул аймгийн Их дээд сургууль болон Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн МСҮТ, коллеж төгсөж ажилд орж байгаа бөгөөд 112 хүн төгсөгч ажилд авснаас 25.9% нь техникийн мэргэжилтэй, 74.1 % нь бакалаврын

боловсролтой хүмүүсийг ажилд авсан байна. Судалгаанд хамрагдсан ажил олгочдоос сүүлийн нэг жилд нягтлан 7, токарьчин 7, сувилагч 6, цэцэрлэгийн багш 6, агрономич 5, геологич 5, биологийн багш 5, химийн багш 4, биеийн тамирын багш 4, бага ангийн багш 4, барилга засал чимэглэл 4, англи хэлний багш 4, сантехник засварчин 4, эрх зүйч 3, дүрслэх урлагийн багш 3, хүнсний үйлдвэрлэлийн технологич 3, эдийн засагч 3, физикийн багш 3, хүний их эмч 3, тогооч 3, гагнуурчин 3, ойжуулалтын анги 3, компьютер програмист 3, багш арга зүйч 3, эрх зүйч 3, механик инженер 3, дуу хөгжмийн багш 2, газар зүй байгаль шинжээч 2, зөгийчин 2, татварын эдийн засагч нягтлан бодогч 2 нийт 112 төгсөгч ажилтай болсон байна (Хүснэгт 3.2.1.3).





Танай байгууллага сүүлийн 3 жилд ажилтан ажлаас халсан уу гэсэн асуултанд 61.6 % нь тийм, 38.4% нь үгүй гэж хариулсан байна. Судалгаанд хамрагдагсдын ажлаас гарсан шалтгаануудыг харахад 22 хувь өөр ажилд шилжихээр болсон, 16 хувь ажлын хариуцлага сахилга бат алдсан, 16 хувь өөр газар руу шилжин суурьшсан, 13 хувь тэтгэвэрт гарсан, 8 хувь эрүүл мэндийн шалтгаанаар, 7 хувь түр ажлын байранд орсон, 5 хувь мэргэжлийн ур чадвар дутмаг, 5 хувь цалин бага, 4 хувь ажлын байрны орон тоо хасагдсан, 3 хувь бусад шалтгаанууд нөлөөлдөг байна. Эдгээр шалтгаануудаас 64 хувь нь өөрийн хүсэлтээр, үлдсэн 36 хувь нь ямар нэгэн ур чадвар дутмаг хариуцлага алдсанаас болж ажил олгогч талаас халж байна. Иймээс ажил горилогч залуучууд өөрсдийгөө чадавхжуулах, ажлын хариуцлагатай, сахилга баттай, ачаалал даах чадвартай ажиллах, зөв хандлагатай болох тал дээр анхаарах нь зүйтэй юм (Зураг 3.2.1.3).



Зураг 3.2.1.3 Ажиллагсдын ажлаас гарсан шалтгаан

### 3.2.2. Ажил эрхэлж буй залуучуудаас авсан санал асуулга

Таны хувьд ажиллах ямар нөхцөл хамгийн чухал вэ? гэсэн асуултанд судалгаанд оролцогчдын 590 иргэн буюу 80,8 хувь нь өндөр чухал хөлс, 77 нь буюу 10.5 хувь нь эрүүл мэндийн даатгал, орон сууцаар хангагдах гэдэг хариултыг өгснөөс үзвэл байгууллага ажиллагчдынхаа энэ 3 хэрэгцээг анхаарах шаардлагатай болох нь харагдаж байна (Хүснэгт 3.2.2.1).

Хүснэгт 3.2.2.1. Ажлын нөхцөл

д/д	Үзүүлэлт	Таны нас						Нийт
		15-24	24-34	35-39	40-45	46-50	51-60	
1.	Өндөр цалин хөлс	68	425	59	22	5	11	590
2.	Эрүүл мэндийн даатгал	11	19	5	3	0	2	40
3.	Орон сууцаар хангах	9	26	0	0	2	0	37
4.	Сургалт	9	8	2	1	0	0	20
5.	Албаны унаа, гар утас	1	2	0	0	0	0	3
6.	Өндөр насны нэмэлт тэтгэвэр олгох тогтолцоо	1	5	1	0	1	1	9
7.	Хүүхдийн сургалтын төлбөрийн туслалцаа	0	4	3	1	0	0	8
8.	Хоол, унааны зардлын хөнгөлөлт	0	1	0	0	0	0	1
9.	<b>Бусад</b>	<b>8</b>	<b>11</b>	<b>2</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>22</b>
	<b>Нийт</b>	<b>107</b>	<b>501</b>	<b>72</b>	<b>28</b>	<b>8</b>	<b>14</b>	<b>730</b>

Сургууль төгсөөд аймагтаа ажиллаж байгаа иргэдийн 78.9 хувь нь буюу 431 нь өөрийн ажиллах боломжоо нэмэгдүүлэхийн тулд шинэ мэргэжил эзэмших, боловсролоо ахиулах төлөвлөгөөтэй байна. Харин 115 иргэн буюу 21.1 хувь нь сургуулиа төгсөөд аймагтаа ажиллахгүй байгаа хэдий ч ажиллах боломжоо нэмэгдүүлэхийн тулд шинэ мэргэжил эзэмших, боловсролоо ахиулах төлөвлөгөөтэй байна (Хүснэгт 3.2.2.2).

Хүснэгт 3.2.2.2. Мэргэжил, боловсролоо дээшлүүлэх төлөвлөгөөтэй эсэх

		Та ажиллах боломжоо нэмэгдүүлэхийн тулд шинэ мэргэжил эзэмших, боловсролоо ахиулах төлөвлөгөөтэй байгаа юу?		Нийт
		Тийм	Үгүй	
Сургуулиа төгсөөд аймагтаа ажиллаж байгаа юу?	Тийм	431	95	526
	Үгүй	115	21	136
<b>Нийт</b>		<b>546</b>	<b>116</b>	<b>662</b>



Судалгаанд оролцогчдоос та сургуулиа төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа юу гэсэн асуултанд 73.2 хувь нь тийм, мэргэжлээрээ ажиллаж байгаа гэж хариулсан бөгөөд эмэгтэйчүүдийн 74.4 хувь нь мэргэжлээрээ ажиллаж байгаа юм байна (Хүснэгт 3.2.2.3).

Хүснэгт 3.2.2.3. Мэргэжлээрээ ажиллах эсэх

		Та сургууль төгсөөд мэргэжлээрээ ажиллаж байгаа юу?		Нийт
		Тийм	Үгүй	
Таны хүйс	Эр	140	59	199
	Эм	338	116	454
<b>Нийт</b>		<b>478</b>	<b>175</b>	<b>653</b>

Судалгаанд оролцогчдын ажилд орохдоо гол анхаарсан хүчин зүйлсийг эрэмбэлэж үзэхэд хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, өсөн хөгжих боломж, байгууллагын нэр хүндийг хамгийн чухал хүчин зүйл гэж үзсэн бөгөөд ажилдаа сэтгэл ханамжтай байдаг эсэхийг тодруулахад судалгаанд оролцсон нийт 666 ажиллагчдын 90.9 хувь нь сэтгэл хангалуун байдаг гэж хариулсан байна (Хүснэгт 3.2.2.4).

Хүснэгт 3.2.2.4. Ажилд орохдоо анхаарах хүчин зүйлс

д/д	Ажилд орох хүсэлт гаргахдаа ямар хүчин зүйлсийг анхаарсан бэ?	Та одоо хийж буй ажилдаа сэтгэл хангалуун байдаг уу?		Нийт	Дүнд эзлэх хувь
		Тийм	Үгүй		
1.	Хөдөлмөрийн нөхцөл аюулгүй ажиллагаа	210	20	230	34.5
2.	Өсөн хөгжих боломж	120	11	131	19.7
3.	Байгууллагын нэр хүнд	103	10	113	17.0
4.	Цалин хөлс	55	7	62	9.3
5.	Ажлын ачаалал, ажлын цаг	39	7	46	6.9
6.	Ажил гэрийн хоорондын зай	30	5	35	5.2
7.	Хувийн зан чанарт нийцэх байдал	30	2	32	4.8
8.	Ажлын чиг үүргийн хүндрэл	16	1	17	2.6
<b>Нийт</b>		<b>603</b>	<b>63</b>	<b>666</b>	<b>100</b>

Харин одоо хийж байгаа ажилдаа сэтгэл ханамжтай байдаг гэж эмэгтэйчүүдийн 89.5 хувь нь, эрэгтэйчүүдийн 91.3 хувь нь хариулсан байна (Хүснэгт 3.2.2.5).

Хүснэгт 3.2.2.5. Ажилдаа сэтгэл ханамжтай байдал

		Та одоо хийж буй ажилдаа сэтгэл хангалуун байдаг уу?		Нийт
		Тийм	Үгүй	
Таны хүйс	эр	189	18	207
	эм	445	52	497
Нийт		634	70	704

